



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit01@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	16
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠐᠎ᠠ. ᠐᠗. ᠒᠑ № ᠑᠐
танай _____-ны № _____-Т

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.УУГАНЦЭЦЭГ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,168,014.89	48,168,591.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	307,437.00	60,200.00
335	Бусад авлага	307,437.00	60,200.00
3351	Байгууллагаас авах авлага	298,930.00	60,200.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,507.00	-
34	УРЬДЧИЛГАА	300,000.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	300,000.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	300,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	49,560,577.89	48,108,391.50
351	Түүхий эд материал	4,613,271.89	6,763,628.50
35110	Тусгай зориулалттай материал	1,447,061.89	3,630,036.50
35130	Эм боох материал	1,673,960.00	3,012,470.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,492,250.00	121,122.00
354	Хангамжийн материал	44,947,306.00	41,344,763.00
35410	Бичиг хэргийн материал	1,689,750.00	2,237,950.00
35420	Аж ахуйн материал	31,093,352.00	29,268,074.00
35430	Сэлбэг хэрэгсэл	785,000.00	517,500.00
35450	Барилгын засварын материал	1,432,700.00	1,214,000.00
35460	Хүнсний материал	1,829,300.00	320,035.00
35470	Бусад хангамжийн материал	8,117,204.00	7,787,204.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	855,941,262.53	751,806,529.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	855,941,262.53	751,806,529.49
392	Биет хөрөнгө	820,797,262.53	716,662,529.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	786,826,654.00	727,969,464.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(80,761,815.89)	(99,622,725.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	19,800,000.00	19,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,575,000.00)	(6,875,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,535,735.66	143,157,647.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(139,139,229.37)	(124,701,813.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,778,842.66	89,303,292.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(87,065,477.53)	(69,357,959.90)
39217	Ном	34,397,553.00	36,989,623.99
393	Биет бус хөрөнгө	35,144,000.00	35,144,000.00
39301	Програм хангамж	772,500.00	497,500.00
39303	Хасагдуулга	(772,500.00)	(497,500.00)
39304	Бусад биет бус хөрөнгө	35,144,000.00	35,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	906,109,277.42	799,975,120.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	143,200.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	143,200.00
413	Өглөг	-	143,200.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	128,700.00
4136	Бусад өглөг	-	14,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	14,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	906,109,277.42	799,831,920.99
51	Засгийн газрын хувь оролцоо	906,109,277.42	799,831,920.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,281,539,528.80	1,281,539,528.80
51101	Өмч: - төрийн	1,281,539,528.80	1,281,539,528.80

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	(462,200,544.68)	(515,326,711.11)
51210	Өмнөх үеийн үр дүн	(462,200,544.68)	(409,049,354.68)
51220	Тайлант үеийн үр дүн		(106,277,356.43)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	86,770,293.30	33,619,103.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>906,109,277.42</u>	<u>799,975,120.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	896,122,746.89	934,720,501.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,755,246.89	16,002,945.60
120	Нийтлэг татварын бус орлого	12,755,246.89	16,002,945.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,755,246.89	16,002,945.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,756,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,755,246.89	7,246,445.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	111,318,300.00	119,077,456.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	772,049,200.00	799,640,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10,683,456.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,683,456.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	111,318,300.00	107,998,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	111,318,300.00	107,998,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	395,400.00
1330	Төсвийн захирагчдаас	-	395,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	937,571,307.85	986,699,876.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,571,307.85	986,699,876.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	895,478,607.04	944,477,596.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,441,567.03	652,188,460.52
210101	Үндсэн цалин	412,822,406.50	403,787,303.57
210102	Нэмэгдэл	150,523,912.27	194,124,502.82
210104	Урамшуулал	52,095,248.26	54,276,654.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,838,314.01	84,065,089.61
210201	Тэтгэврийн даатгал	53,054,332.35	59,658,895.44
210202	Тэтгэмжийн даатгал	6,204,330.57	6,131,173.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,088,722.46	4,905,638.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,135,541.70	1,737,964.09
210205	Эрүүл мэндийн даатгал	11,355,386.93	11,631,417.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,143,805.95	102,997,129.32
210301	Гэрэл, цахилгаан	2,571,925.95	4,243,749.32
210302	Түлш, халаалт	102,506,880.00	98,093,380.00
210303	Цэвэр, бохир ус	1,065,000.00	660,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,245,912.60	11,534,200.00
210401	Бичиг хэрэг	1,516,950.00	899,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,390,246.00	2,413,122.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,446,000.00	651,000.00
210404	Ном, хэвлэл	12,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	176,000.00	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,870,300.00	2,469,200.00
210408	Бараа материал акталсны зардал	3,834,416.60	5,021,078.00

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	10,854,793.00	13,464,095.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,222,295.00	1,104,275.00
210502	Хоол, хүнс	8,632,498.00	11,743,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	616,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,776,700.00	8,581,560.00
210604	Урсгал засвар	4,776,700.00	8,581,560.00
2107	Томилолт, зочны зардал	-	348,350.00
210702	Дотоод албан томилолт		348,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,268,000.00	1,473,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	548,000.00	609,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	864,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,909,514.45	69,825,512.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,042,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,664,800.00	6,648,590.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,244,714.45	58,134,222.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,092,700.81	42,222,279.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,530,210.00	33,954,818.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	820,000.00	987,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,710,210.00	32,967,318.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,562,490.81	8,267,461.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,562,490.81	8,267,461.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(41,448,560.96)	(51,979,374.85)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		54,297,981.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		54,297,981.58
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(54,297,981.58)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(41,448,560.96)	(106,277,356.43)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн /Төгрөгөөр/
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,246,395,528.80	21,716,003.30	(58,046,187.25)	1,210,065,344.85
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,246,395,528.80	21,716,003.30	(58,046,187.25)	1,210,065,344.85
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(31,306,942.78)	(31,306,942.78)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,281,539,528.80	86,770,293.30	(462,200,544.68)	906,109,277.42
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,281,539,528.80	86,770,293.30	(462,200,544.68)	906,109,277.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	53,151,190.00	53,151,190.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,281,539,528.80	86,770,293.30	(409,049,354.68)	959,260,467.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(53,151,190.00)	-	(53,151,190.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(106,277,356.43)	(106,277,356.43)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,281,539,528.80	33,619,103.30	(515,326,711.11)	799,831,920.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	885,675,300.00	924,692,756.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,307,800.00	5,975,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,307,800.00	5,975,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,307,800.00	4,218,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,307,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,218,000.00
120009	Бусад орлого	-	1,757,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	883,367,500.00	918,717,556.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	772,049,200.00	799,640,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10,683,456.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,683,456.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	111,318,300.00	108,394,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	111,318,300.00	107,998,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	395,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	875,677,300.00	920,884,456.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,677,300.00	920,884,456.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,199,909.19	880,060,304.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,677,227.03	651,874,868.26
210101	Үндсэн цалин	413,058,066.50	403,787,303.57
210102	Нэмэгдэл	150,523,912.27	193,810,910.56
210104	Урамшуулал	52,095,248.26	54,276,654.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,784,710.21	83,791,644.87
210201	Тэтгэврийн даатгал	53,000,727.55	59,385,450.70
210202	Тэтгэмжийн даатгал	6,204,331.57	6,131,173.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,088,722.46	4,905,638.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,135,541.70	1,737,964.09
210205	Эрүүл мэндийн даатгал	11,355,386.93	11,631,417.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,003,805.95	102,997,129.32
210301	Гэрэл, цахилгаан	2,571,925.95	4,243,749.32
210302	Түлш, халаалт	102,366,880.00	98,093,380.00
210303	Цэвэр, бохир ус	1,065,000.00	660,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,567,946.00	8,482,522.00
210401	Бичиг хэрэг	739,800.00	615,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,390,246.00	2,413,122.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,446,000.00	651,000.00
210404	Ном, хэвлэл	2,384,200.00	1,764,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	176,000.00	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,431,700.00	2,958,100.00
2105	Нормативт зардал	14,420,400.00	12,576,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,202,510.00	1,352,885.00
210502	Хоол, хүнс	10,353,190.00	10,247,055.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	864,700.00	976,200.00

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,093,050.00	7,727,060.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	166,000.00	
210604	Урсгал засвар	4,927,050.00	7,727,060.00
2107	Томилолт, зочны зардал	-	348,350.00
210702	Дотоод албан томилолт		348,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,268,000.00	1,557,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	548,000.00	693,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	864,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,384,770.00	10,704,890.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,384,770.00	10,704,890.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,477,390.81	40,824,151.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,914,900.00	32,556,690.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	820,000.00	987,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,094,900.00	31,569,190.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,562,490.81	8,267,461.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,562,490.81	8,267,461.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		<u>3,808,300.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,998,000.00	3,808,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,998,000.00	3,808,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,998,000.00	3,808,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,998,000.00	3,808,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,998,000.00)</u>	<u>(3,808,300.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	907,638,700.00	899,400,283.45	8,238,416.55	99.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	907,638,700.00	899,400,283.45	8,238,416.55	99.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	874,504,400.00	866,843,593.45	7,660,806.55	99.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	658,632,300.00	651,874,868.26	6,757,431.74	98.97
210101	Үндсэн цалин	490,411,400.00	403,787,303.57	86,624,096.43	82.34
210102	Нэмэгдэл	120,110,400.00	193,810,910.56	(73,700,510.56)	161.36
210103	Урамшуулал	48,110,500.00	54,276,654.13	(6,166,154.13)	112.82

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,653,200.00	83,791,644.87	861,555.13	98.98
210201	Тэтгэврийн даатгал	62,853,100.00	59,385,450.70	3,467,649.30	94.48
210202	Тэтгэмжийн даатгал	5,450,000.00	6,131,173.58	(681,173.58)	112.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,360,000.00	4,905,638.88	(545,638.88)	112.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,090,000.00	1,737,964.09	(647,964.09)	159.45
210205	Эрүүл мэндийн даатгал	10,900,100.00	11,631,417.62	(731,317.62)	106.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,998,600.00	102,997,129.32	1,470.68	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,968,400.00	4,243,749.32	(275,349.32)	106.94
210302	Түлш, халаалт	98,230,200.00	98,093,380.00	136,820.00	99.86
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	660,000.00	140,000.00	82.50
2104	Хангамж, бараа материалын зардал	7,117,900.00	7,120,322.00	(2,422.00)	100.03
210401	Бичиг хэрэг	751,300.00	615,500.00	135,800.00	81.92
210402	Тээвэр, шатахуун	2,436,800.00	2,413,122.00	23,678.00	99.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	751,300.00	616,000.00	135,300.00	81.99
210404	Ном, хэвлэл	300,500.00	163,000.00	137,500.00	54.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,400.00	80,000.00	145,400.00	35.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,652,600.00	3,232,700.00	(580,100.00)	121.87
2105	Нормативт зардал	11,910,500.00	11,908,585.00	1,915.00	99.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	685,700.00	685,330.00	370.00	99.95
210502	Хоол, хүнс	10,248,100.00	10,247,055.00	1,045.00	99.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	976,700.00	976,200.00	500.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,988,060.00	11,940.00	99.76
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,988,060.00	11,940.00	99.76
2107	Томилолт, зочны зардал	375,700.00	348,350.00	27,350.00	92.72
210702	Дотоод албан томилолт	375,700.00	348,350.00	27,350.00	92.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	773,400.00	772,500.00	900.00	99.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,400.00	224,500.00	900.00	99.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	548,000.00	548,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,042,800.00	3,042,134.00	666.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,042,800.00	3,042,134.00	666.00	99.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,134,300.00	32,556,690.00	577,610.00	98.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,134,300.00	32,556,690.00	577,610.00	98.26
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,014,900.00	987,500.00	27,400.00	97.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,119,400.00	31,569,190.00	550,210.00	98.29

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	907,638,700.00	907,638,700.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	799,640,100.00	799,640,100.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	799,640,100.00	799,640,100.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,998,600.00	107,998,600.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	107,998,600.00	107,998,600.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ Тайлант оны
		Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,025,011.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,025,011.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,025,011.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,167,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,000.00
210404	Ном, хэвлэл	1,736,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	395,400.00
2105	Нормативт зардал	667,555.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	667,555.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,739,000.00
210604	Урсгал засвар	2,739,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	785,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	469,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	316,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,666,056.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,666,056.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,901,456.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,218,000.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,218,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,683,456.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,683,456.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн

зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 18,751.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15,001.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	307.4	60.2	(247.2)
Урьдчилгаа	300.0	-	(300.0)
Бараа материал	49,560.6	48,108.4	(1,452.2)
Үндсэн хөрөнгө	855,941.3	751,806.5	(104,134.8)
Нийт хөрөнгө	906,109.3	799,975.1	(106,134.2)
Өр төлбөр	-	143.2	143.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	906,109.3	799,831.9	(106,277.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	906,109.3	799,975.1	(106,134.2)

Авлага дансны үлдэгдэлд байгууллагаас авах 35.0 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 25.2 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Урьдчилгаа данс 300.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48,108.4 мянган төгрөг болж, 1,452.2 мянган төгрөгөөр буурсан нь Боловсрол соёлын газраас ирсэн 1-5 ангийн хүүхдийн хичээлийн хэрэгсэл, автомаксын 622.9 мянган төгрөгөөр, 1 иргэнээс хандивласан 837.0 мянган төгрөгийн хивсэнцэр, Дарьганга сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 3 ширхэг 225.0 мянган төгрөгийн үнэтэй ус буцалгагч, үндсэн хөрөнгийн устгалаас орлогодсон 4,538.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал зарцуулагдсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 751,806.5 мянган төгрөг болж, 104,134.8 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс 1 иргэнээс хандивласан 1,903.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Боловсрол шинжлэх ухааны яамнаас хандиваар ирсэн 2,457.1 мянган төгрөгийн сурах бичиг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,937.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн. Үндсэн хөрөнгийн данс акталж устгасан 102,832.0 мянган төгрөгийн хөрөнгөөр, Халзан сумын Тохижилт үйлчилгээний газарт шилжүүлсэн уурын зуухны тогооны 19,856.0 мянган төгрөгийн, тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2 хувь хүнтэй холбоотой ХХОАТ-ын суутгалд төлөх 128.7 мянган төгрөгийн, бараа ажил үйлчилгээнд төлөх 14.5 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлогын дүн 36,289.9 мянган төгрөгөөр буурсан. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 10,683.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 47,087.6 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,115,923.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,115,923.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 208,285.0 мянган төгрөгөөр бууруулж, 907,638.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 907,638.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 799,640.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 107,998.6 мянган орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 799,640.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 107,988.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 907,638.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 899,400.3 мянган төгрөгийг зарцуулж, 8,238.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Отрын багш төслөөр Боловсрол шинжлэх ухааны газраас 10,384.2 мянган төгрөг, бичгийн цаасны 299.3 мянган төгрөг, ариутгалын бодис зарцуулахтай холбоотой 395.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн устгалаас 4,218.0 мянган төгрөг, ном түрээслэсний 1,736.8 мянган төгрөг, нийт 17,033.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 17,025.0 мянган төгрөгийг зарцуулж, 8.7 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 751,806.5 мянган төгрөг болж, 104,134.8 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс 1 иргэнээс хандивласан 1,903.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Боловсрол шинжлэх ухааны яамнаас хандиваар ирсэн 2,457.1 мянган төгрөгийн сурах бичиг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,937.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн. Үндсэн хөрөнгийн данс акталж устгасан 102,832.0 мянган төгрөгийн хөрөнгөөр, Халзан сумын Тохижилт үйлчилгээний газарт шилжүүлсэн уурын зуухны тогооны 19,856.0 мянган төгрөгийн, тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр хасагдсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 938,073.5 мянган төгрөгийн 58 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 812,663.5 мянган төгрөгийн 38 мэдээллийн огт байршуулаагүй, 125,409.9 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад орон тоо хүнээр нэмэгдэж, хөрөнгө бэлтгээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,488.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд тогтоосон төлбөрийн актыг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,488.0	1	1,488.0			100.0
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	1,488.0	1	1,488.0	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 947,801.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 681.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,013.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,830.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 938,073.4 мянган төгрөгийн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй, 203.4 мянган төгрөгийн авлага, өр төлбөр болон үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй шилжин ирсэн 1,135.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 454.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан үлдэгдэл өртгийн буюу 681.0 мянган төгрөгийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 1 дүгээр хавсралт Үндсэн хөрөнгийн бүртгэл хэсгийн 4.33-д “Бэлэг, хандивын хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн зах зээлийн /авсан өдрийн бодит үнэ/ үнийг ашигладаг. ,, ,,”, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө-ийн параграф 27-д “Хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртгийг тэрхүү олж эзэмшилтийн өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжинэ”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэ төлбөргүй шилжин ирсэн 869.5 мянган төгрөгийн анхны өртөг болон 54.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бууруулан, үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан үлдэгдэл өртгийн буюу 815.1 мянган төгрөгийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч бүртгэн залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 441.2 мянган төгрөгийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.4.1-д " Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 зүйлийн 7.7-д Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах,,", УСНББОУС 12 бараа материалд тавигдах шаардлага, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

2. Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 3 ажилтны цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцооноос 2,572.0 мянган төгрөгийг илүү суутгасан;

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Нийт 8 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 5,830.8 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагаас авах 35.0 мянган төгрөгийн, 1 хувь хүнээс авах 25.2 мянган төгрөгийн, нийт 60.2 мянган төгрөгийн авлагатай байна. Үүнээс 1 аж ахуйн нэгж байгууллагаас авах 35.0 мянган төгрөгийн, 1 хувь хүнээс авах 25.2 мянган төгрөгийн, нийт 60.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,,” мөн хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, УСНББОУС-ын үндсэн шаардлага, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж авлага үүсгэхгүй ажиллах, холбогдох хууль журмын дагуу авлагыг барагдуулах, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

2. Өглөгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагад өгөх 14.5 мянган төгрөгийн, 2 хувь хүнд өгөх 128.7 мянган төгрөгийн, нийт 143.2 мянган төгрөгийн өр төлбөртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, холбогдох заавар журмыг мөрдөж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өглөгийг холбогдох заавар журмын дагуу төлж барагдуулах

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 725 ширхэг 145,372.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 938,073.5 мянган төгрөгийн 58 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 812,663.5 мянган төгрөгийн 38 мэдээллийн огт байршуулаагүй, 125,409.9 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасаагүй дүнгээр тайлагнасан	1	681.0	1	681.0						
2	Хүнсний материал нөөцөлсөн	1	441.2			1	441.2				
3	Авлага үүсгэн ажилласан	1	60.2							1	60.2
4	Өр төлбөр үүсгэн ажилласан	1	143.2							1	143.2
5	Худалдан авалтыг Татварын цахим системд бүртгээгүй, И баримтаар баталгаажуулаагүй	1	5,830.8					1	5,830.8		
6	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
7	Цалин буруу тооцож олгосон	1	2,572.0			1	2,572.0				
Дүн		6	9,728.4	1	681.0	1	3,013.2	1	5,830.8	3	203.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	938,073.4							1	938,073.4
Дүн		1	938,073.4	-	-	-	-	-	-	1	938,073.4
Нийт дүн		7	947,801.8	1	681.0	1	3,013.2	1	5,830.8	4	938,276.8